

ЖИРЭМСНИЙ ҮЕИЙН ЧИХРИЙН ШИЖИН: ЭХ БАРИХЫН АСУУДАЛ БА МЕНЕЖМЕНТ

ЗОХИОГЧ: Michael Pignone, MD, MPH

ЭМХЭТГЭСЭН: Т.Оюундарь

ОРЧУУЛСАН: Ш. Бүжинлхам, С. Өлзийзаяа

Эх сурвалжийн сүүлд шинэчлэгдсэн огноо: 2023.11

ХЯНАН ТОХИОЛДУУЛСАН: Ц.Энх-Оюун

Нийтлэгдсэн огноо: 2023.04

ХУРААНГУЙ

Жирэмсний чихрийн шижинтэй (ЖИШ) өвчтөнүүдийн эмчлэгч эмч нь тухайн өвчний эх, урагт үзүүлэх үр дагаврын (жишээ нь преэклампси ба макросоми буюу ураг хэт томрох эрсдэл нэмэгдэх), гипергликемийн менежмент, жирэмсний хяналт, жирэмсний хүндрэлийн менежмент, төрсний дараах тусламж, урт хугацааны хяналт зэргийн талаар мэдлэгтэй байх ёстой. Энэхүү сэдэвт дээрх асуудлын талаар хэлэлцэх ба глюкозын менежментийг тусад нь нарийвчлан авч үзнэ.

- ("Жирэмсний чихрийн шижин: Глюкозын менежмент ба жирэмслэлтийн явц" сэдвийг үзнэ үү.)
- ("Жирэмслэлтийн өмнөх (өмнө нь чихрийн шижин оношлогдсон) болон жирэмсний үеийн чихрийн шижин: Төрөх болон төрсний дараах үеийн глюкозын менежмент" сэдвийг үзнэ үү.)

ЖЧШ-гийн эрт илрүүлэг, оношилгоог өөр бүлэгт хэлэлцэнэ. ("Жирэмсний үеийн чихрийн шижин: Эрт илрүүлэг, оношилгоо, урьдчилан сэргийлэх" хэсгийг үзнэ үү.)

ЖИРЭМСНИЙ ЧИХРИЙН ШИЖИНГИЙН ҮР ДАГАВАР

Хүн амын дунд глюкозын солилцооны бууралттай хүмүүс ихсэхийн хэрээр жирэмслэлтийн ердийн асуудлаас гадна ЖЧШ-тэй өвчтөнүүдийн төрөхийн өмнөх хяналт нь урьдчилан сэргийлэх, тодорхойлох, зохицуулахад чиглэж байна. Жирэмсний өмнөх чихрийн шижинтэй өвчтөнүүдээс ялгаатай нь жинхэнэ ЖЧШ -тэй өвчтөнүүдэд эмгэг нь органогенезийн үндсэн үеэс хойш тохиолддог учраас төрөлхийн гажиг үүсэх эрсдэл өндөр байдаггүй. Үүний нэгэн адил эмгэг нь богино хугацаанд үргэлжилдэг тул чихрийн шижинтэй холбоотой судасны эмгэг мөн үүсдэггүй боловч ЖЧШ -тэй гэж оношлогдсон зарим өвчтөнд жирэмслэхээс өмнө эсвэл жирэмсний эхэн үед чихрийн шижинтэй байсан эсэхийг илрүүлээгүй тохиолдолд эдгээр хүндрэлүүд гарч болзошгүйг анхаарах нь чухал юм.

Богино хугацааны үр дагавар – ЖЧШ - тэй өвчтөнүүдэд ихэвчлэн тохиолддог жирэмсний хүндрэлүүд нь:

- Жирэмсний хугацаанаас ураг том байх, макросоми буюу ураг хэт томрох – Жирэмсний хугацаанаас ураг том байх гэдэг нь жирэмсний хугацаанаас ургийн жин болон нярайн жин 90-р центиль-ээс дээш байхыг (10 ургийн 9-өөс нь дээш жинтэй) хэлэх ба макросоми нь ЖЧШ-тэй ихэвчлэн холбоотой үүсдэг. Таргалалт, жирэмсний үеийн жин нэмэгдэх нь голлох нөлөө үзүүлдэг.
- АНУ-д 1.5 сая гаруй нэг урагтай, хэвийн амьд төрөлтөд (2014-2020 он) жирэмсний хугацаанаас ураг том байх болон макросоми (төрөх үеийн жин >4000 гр гэж тодорхойлсон) тус тус 18.0 ба 10.5% байна [1].
- ЖЧШ нь жирэмсний хугацаанаас ураг том байх эрсдэлийг хоёр дахин нэмэгдүүлж, таргалалттай өвчтөнүүд илүү өндөр эрсдэлтэй байдаг. Нэг судалгааны үр дүнд [2]:
- ЖЧШ-тэй болон ЖЧШ-гүй хэвийн жинтэй хүмүүст жирэмсний хугацаанаас ураг том байх тархалт 13.6%, 7.7% тус тус байсан.
- Таргалалттай хүмүүсийн хувьд, ЖЧШ-тэй болон ЖЧШ-гүй бүлгүүдэд жирэмсний хугацаанаас ураг том байх тархалт 22.3%, 12.7% тус тус байсан байна.
- Мөн судалгаагаар жирэмсэн үеийн эхийн жингийн хэт их өсөлт (>40 фунт [18 кг]) нь жирэмсний хугацаанаас ураг том байх эрсдэлийг хоёр дахин нэмэгдүүлж байсан [3].

Санамсаргүй туршилт судалгаануудад эхийн гипергликеми нь жирэмсний хугацаанаас ураг том байх эсвэл макросоми нярай хүүхэдтэй болох эрсдэлийг ихээхэн нэмэгдүүлдэг болохыг харуулсаар байна [4-7]. Эхийн өлөн үеийн сийвэнгийн глюкозын хэмжээ ихсэх тусам эдгээр үр дагаврын эрсдэл тасралтгүй нэмэгддэг. Эхийн гипергликеми нь глюкоз болон бусад шим тэжээлийн бодисыг ихсээр дамжуулж, ургийн гиперинсулинизмыг өдөөж, улмаар ургийн тэгш бус өсөлтийг хурдасгахад хүргэдэг (чихрийн шижингүй эхээс төрсөн нярай хүүхэдтэй харьцуулахад толгойн хэмжээ хэвийн боловч өргөн мөр, цээж, хэвлийн диаметр өсдөг). Проспектив когорт судалгаагаар ургийн хурдацтай өсөлт нь жирэмсний 20-28 долоо хоногтойгоос эхэлж байгааг харуулсан байна [8].

Макросоми ба ургийн их биеийн тэгш бус байдал нь мэс заслын төрөлт (кесар хагалгаа эсвэл багажийн тусламжтайгаар үтрээгээр төрүүлэх), төрөх үеийн гэмтэл, нярайн хүндрэл, тухайлбал мөрний дистоци болон түүнтэй холбоотой хүндрэлүүд: мөрний сүлжээний гэмтэл, хугарал, нярайн хямрал зэрэг эрсдэлүүдийг үүсгэдэг байна [9-16]. ("Ургийн макросоми" ба "Мөрний дистоци: эрсдэлт хүчин зүйлс ба эрсдэлтэй жирэмслэлтийн төлөвлөлт" болон "Жирэмсний хугацаанаас ураг том байх" хэсгийг үзнэ үү.)

- Преэклампси ба жирэмсний гипертензи – ЖЧШ-тэй өвчтөнүүд ЖЧШ-гүй өвчтөнүүдтэй харьцуулахад преэклампси болон жирэмсний гипертензи үүсэх эрсдэл өндөр байдаг (нийт давтамж 12% [1]). Инсулины эсэргүүцэл нь ЖЧШ-г үүсгэдэг бөгөөд энэ нь преэклампси болон жирэмсний гипертензи үүсэхтэй холбоотой байдаг [17-26]. ("Преэклампси: Эмнэлзүйн шинж тэмдэг, оношилгоо" ба "Жирэмсний гипертензи"-ийг үзнэ үү.)
- Полигидрамниоз – ЖЧШ-тэй өвчтөнүүдэд полигидрамниоз илүү их тохиолддог (тохиолдол 18% [27]). Эмгэгжамын шалтгаан нь тодорхойгүй бөгөөд ургийн гипергликемийн улмаас ургийн хоёрдогч полиури үүсдэг нь боломжит эмгэг жамын тайлбар юм. Жирэмслэлтийн явцад үзүүлэх нөлөө нь мөн тодорхойгүй хэвээр байна. ЖЧШ-тэй холбоотой полигидрамниоз нь ихэвчлэн хөнгөн байдаг ба перинаталь өвчлөл, нас баралтыг төдийлөн нэмэгдүүлдэггүйг хоёр судалгааны үр дүн харуулж байна [28,29]. Гэсэн хэдий ч зарим судалгаагаар ЖЧШ-тэй эсвэл ЖЧШ-гүй өвчтөнүүдийн полигидрамниоз нь жирэмсний сөрөг үр дагаварт хүргэх эрсдэлтэй гэж үзэж байна [27]. ("Полигидрамниоз: Шалтгаан, оношилгоо, менежмент" бүлгийн "Үр дагавар" хэсгийг үзнэ үү.)
- Амьгүй төрөлт – Нийт хүн амтай харьцуулахад ЖЧШ-тэй өвчтөнүүдэд амьгүй ураг төрүүлэх эрсдэл бага зэрэг нэмэгддэг. ЖЧШ-тэй 103,000 жирэмсэн эхийг хамруулсан системчилсэн тойм судалгаагаар амьгүй төрөлтийн түвшин ЖЧШ-тэй 1000 жирэмслэлт тутамд 6 амьгүй төрөлт байсан бол ЖЧШ-гүй 1000 жирэмслэлт тутамд амьгүй төрөлт 4 байв [30]. Гэсэн хэдий ч амьгүй төрөх эрсдэл нэмэгдэж байгаа нь гликемийн хяналт муутай холбоотой байх магадлалтай бөгөөд гликемийн хяналт сайтай өвчтөнүүдэд энэ эрсдэл нэмэгддэггүй боловч сайн хяналттай байх нь хэцүү байдаг [31-34].
- Нярайн өвчлөл ба нас баралт – ЖЧШ-гийн хүндрэлтэй ээжээс төрсөн нярайд гипогликеми, гипербилирубинеми, гипокальциеми, гипомагниеми, полицитеми, амьсгалын замын эмгэг ба/эсвэл кардиомиопати зэрэг олон, түр зуурын өвчнөөр өвчлөх эрсдэл нэмэгддэг [35,36]. Эдгээр эрсдэлүүд нь ихэвчлэн эхийн болон ургийн гипергликемитэй холбоотой байдаг. ("Чихрийн шижинтэй эхийн нярай хүүхдүүд"- хэсгийг үзнэ үү.)

Ихэнх судалгаанаас ялгаатай нь, Жирэмсний Хожуу үеийн Стероидууд (ALPS) туршилт судалгааны үр дүнд хоёрдогч дүн шинжилгээ хийхэд ЖЧШ нь нярайн амьсгалын замын эмгэгт эмнэлзүйн хувьд статистикийн ач холбогдолтой ялгаа ажиглагдаагүй; гэхдээ судалгаанд оролцогч бүрийн глюкозын хяналт, чихрийн шижингийн эмчилгээний талаарх мэдээлэл байхгүй байсан [37]. Гликемийн сайн хяналт нь ЖЧШ-тэй өвчтөнүүдийн нярайд

амьсгалын замын хүндрэл үүсэх эрсдэлийг бууруулсан байж магадгүй юм. Энэ судалгаанд ЖЧШ-тэй өвчтөнүүд болон ЖЧШ-гүй өвчтөнүүдийн хоорондох үндсэн ялгааг тайлбарлаж болно.

Урт хугацааны үр дагавар – ЖЧШ-тэй холбоотой эрсдэлүүд нь жирэмслэлтийн үе болон нярайн үед үзүүлэх нөлөөллөөс даван цаашид үргэлжлэхийг хэлнэ. Жишээлбэл:

- Эхэд үүсэх эрсдэл – ЖЧШ нь ирээдүйд чихрийн шижин хэв шинж 2, бодисын солилцооны хам шинж, зүрх судасны өвчнөөр өвчлөх эрсдэлийг үүсгэх хүчтэй нөлөөлөл юм. ("Жирэмсний үеийн чихрийн шижин: Глюкозын менежмент ба эхийн тавилан", "Урт хугацааны үр дагавар" хэсгийг үзнэ үү.)
- Хүүхдэд үүсэх эрсдэл – ЖЧШ нь хүүхдэд цаашид таргалалт болон глюкозын үл тэсвэржилт үүсэх эрсдэлийг нэмэгдүүлдэг. Жирэмсний үед хяналт муутай чихрийн шижин нь мэдрэлийн тогтолцооны хөгжилд нөлөөлж болзошгүй гэж үздэг ч хангалттай шаардлага хангахуйц чанартай нотлох судалгаа баримт хомс байна. ("Чихрийн шижинтэй эхийн нярай хүүхэд", "Урт хугацааны үр дагавар" хэсгийг үзнэ үү.)

АНГИЛАЛ БА НЭР ТОМЬЁОЛОЛ

ЖЧШ-тэй өвчтөнүүдийг жирэмсний эрсдэлтэй холбоотой хоёр бүлэгт ангилан үзэх [38] ба энэ нь цаашид эх барихын менежменттэй уялдана.

- A1: эм хэрэглэхгүйгээр цусан дахь глюкозын хэмжээг хянах боломжтой
- A2: эмийн тусламжтайгаар цусан дахь глюкозын хэмжээг хянах боломжтой

ТӨРӨХИЙН ӨМНӨХ ТУСЛАМЖ ҮЙЛЧИЛГЭЭ

ЖЧШ-гийн үеийн ерөнхий менежментийг алгоритмд 1-д харуулав.

Глюкозын менежмент — Глюкозын түвшинг зорилтот түвшинд хүргэхийн тулд глюкозын менежмент нь ЖЧШ-тэй холбоотой хүндрэл болон хүндийн зэргийг бууруулах гол арга хэмжээ юм.

- Өөрийн хяналт – Глюкозын хэмжээг өглөөний цайны өмнө (жишээ нь, өлөн үеийн глюкозын хэмжээ) болон хооллолт бүрээс 1-2 цагийн дараа шалгах.
- Гликемийн зорилтот утга – Төрөхийн өмнөх цусан дахь глюкозын хэмжээг тогтоох зорилтот утга:
- Өлөн үеийн цусан дахь глюкозын концентраци: <95 мг/дл (5.3 ммоль/л)
- Хоол идсэнээс нэг цагийн дараах цусан дахь глюкозын концентраци: <140 мг/дл (7.8 ммоль/л)

- Хоол идсэнээс хоёр цагийн дараах глюкозын концентраци: <120 мг/дл (6.7 ммоль/л)

Санамсаргүй туршилт судалгаагаар хоол идсэний дараах глюкозын хэмжээг хянахад илүү хатуу зорилтот утга ашиглах нь жирэмсний хугацаанаас ураг том байх нийт эрсдэлийг бууруулаагүй ч перинатал нас баралт, төрөх үеийн гэмтэл, мөрний дистоци үүсэх эрсдэлийг бууруулсан байна [39].

Глюкозын хяналт муу, оновчтой бус байгааг тодорхойлох стандарт шалгуур тоо байхгүй байна. Глюкозын хэмжээ зорилтот хязгаараас 20-30 хувиар ихэссэн байвал хяналт муу байна гэж үзэж байна.

Эдгээр зорилтод хүрэх, түүнийг хадгалахын тулд глюкозын хяналт, эмчилгээний хоол тэжээл эмчилгээ, дасгал хөдөлгөөн, инсулин болон гипергликемийн эсрэг эмийг хэрэглэх талаар тусад нь авч үзнэ. ("Жирэмсний чихрийн шижин: Глюкозын менежмент ба эхийн таамаглал" хэсгийг үзнэ үү.)

Ургийн тандалт – Глюкозын сайн хяналттай А1 ЖЧШ – Зөвхөн хоол тэжээлийн эмчилгээгээр эугликеми өвчтэй (өөрөөр хэлбэл, А1 ангиллын ЖЧШ) болон жирэмсний бусад хүндрэлгүй (жишээ нь: макросоми, преэклампси, өсөлтийн хязгаарлалт, полигидрамниоз, олигогидрамниоз) өвчтөнүүд амьгүй хүүхэд төрөх эрсдэл байдаггүй [40] ба иймээс жирэмсний үеийн ургийн тандалт (стрессийн бус сорил [NST] ба амнион шингэний индекс, биофизикийн үзүүлэлт [BPP]) -ийг хийхгүй орхих арга барил байдаг боловч уг асуудлын одоо байгаа датан дээр үндэслэсэн эмнэлзүйн удирдамжууд өөр өөр байна. Хэрэв эмч эдгээр жирэмслэлтүүдэд NST эсвэл BPP хийхээр шийдсэн бол 32-36 долоо хоногтой жирэмсэн хүн амд амьгүй төрөлтийн эрсдэл нэмэгдээгүй тул энэхүү шинжилгээг 32 долоо хоногоос эхлэн, 36 долоо хоногоос өмнө хийх ёстой. ("Төрөхийн өмнөх ургийн үнэлгээний тойм" -ыг үзнэ үү.)

Америкийн Эх барих эмэгтэйчүүдийн эмч нарын коллеж (ACOG)-оос амнион шингэний хэмжээг үнэлэхээс бусад тохиолдолд хоол эмчилгээнд хяналт сайтай глюкозын түвшинтэй өвчтөнүүдэд ургийн үнэлгээ хийх талаар тусгай зөвлөмж өгөөгүй [38].

А2 ЖЧШ эсвэл А1 ЖЧШ глюкозын муу хяналттай – Энэ тохиолдолд долоо хоногт 2 удаа NST шинжилгээ мөн жирэмсний 32 долоо хоногоос эхлэн амнион шингэний индекс шинжилгээг хийнэ (алгоритм 1):

- Гликемийг сайн хянах зорилгоор инсулин эсвэл гипергликемийн эм хэрэглэж байгаа бүх өвчтөнүүд.
- Гликемийн хяналт нь муу өвчтөнүүд. Чихрийн шижингийн хяналтыг сайжруулах хамгийн зөв арга нь хоол эмчилгээ болон эмийн эмчилгээ байна.

ЖЧШ-гийн хүндрэлтэй жирэмслэлтийн үед ургийн шинжилгээ хийх үндэслэл нь ЖЧШ-гийн хүндрэлтэй жирэмслэлтийн үед ураг эндэж байгаагүй эсвэл ховор тохиолдож байсан талаар мэдэгдсэн өмнөх олон жилийн мэдээлэл, ажиглалт судалгаанд үндэслэж байна [41,42]. ЖЧШ-тэй өвчтөнүүдийн ургийн тандалт хийн үнэлсэн санамсаргүй хяналтат туршилт судалгаа хийгдээгүй бөгөөд цөөн тооны кохорт болон тохиолдол хяналтын судалгааны үр дүнгүүд тодорхойгүй байна.

Хэдэн арван жилийн турш хөгжиж ирсэн эмнэлзүйн практикт ургийн шинжилгээг хийх суурь үндэслэл нь:

1. ЖЧШ-ийн хүндийн зэрэг (жишээ нь, эугликемид хоол эмчилгээ эсвэл эмийн эмчилгээний тусламжтайгаар хүрсэн эсэх)
2. Жирэмсний сөрөг үр дагаварт хүргэх бусад эрсдэлт хүчин зүйлс байгаа эсэх (жишээ нь, амьгүй хүүхэд төрүүлж байсан түүх, архаг цусны даралт ихсэлт, жирэмсний хугацаанаас ураг том байх/макросоми зэрэг хавсарсан өвчин байгаа эсэх) юм.

Зарим судалгаагаар ЖЧШ-тэй өвчтөнүүдэд амьгүй ураг төрүүлэх эрсдэл нэмэгддэг [43-45]. Бид инсулин эсвэл гипергликемийн эсрэг эмийн эмчилгээ (өөрөөр хэлбэл, А2 ангиллын ЖЧШ) шаардлагатай өвчтөнүүдэд эугликемийг хадгалахыг зөвлөх, эсвэл цусан дахь глюкозын түвшинг муу хянаж байгаа хүмүүсийг жирэмсний үеийн чихрийн шижин, мөн жирэмслэлтийн сөрөг үр дагаварт хүргэх эрсдэлд хүргэдэг бусад эмгэгтэй өвчтөнүүдийн нэгэн адил зөв удирдан чиглүүлэх ёстой гэх мэргэжилтнүүдийн дүгнэлттэй санал нэг байна. Эдгээр өвчтөнүүд ихэвчлэн жирэмсний 32 долоо хоногоос эхлэн ургийн шинжилгээнд үе үе хамрагдах шаардлагатай болдог.

Жирэмсний 3 дахь гурван сараас эхлэн тандалтыг эхлүүлэх хугацаа, шинжилгээ хийх давтамж, ашиглах шинжилгээний арга (NST, BPP эсвэл хоёулаа) зэргийг тухайн эмнэлэг, шинжилгээг хийх нөхцөлөөс хамаарч өөр өөр байдаг. Хэдийгээр ихэнхи тохиолдолд NST шинжилгээг амнион шингэний индекстэй хамт шинжлэх аргаар долоо хоногт хоёр удаа шинжилгээ хийдэг ч долоо хоногт хоёр удаа шинжилгээ хийх эсвэл жирэмсний хожуу үеийнхтэй харьцуулахад 32 долоо хоногтойд шинжилгээг эхлүүлэх нь илүү үр дүнтэй гэх талаар баттай нотолгоо байхгүй байна. Жишээлбэл, зарим эмнэлгүүдэд 32 долоо хоногтойгоос эхлэн долоо хоног бүр NST шинжилгээг хийж эхлэх ба 36 долоо хоногтойгоос долоо хоногт хоёр удаа хийдэг байна.

Америкийн Эх барих эмэгтэйчүүдийн эмч нарын коллеж (ACOG)-оос дараах өвчтөнүүдэд жирэмсний 32 долоо хоногоос эхлэн ургийн үнэлгээ хийхийг санал болгодог: (1) эмийн эмчилгээгээр цусан дахь сахрын хэмжээг сайн хянах боломжтой байсан ч инсулин эсвэл

эмийн эмчилгээ хийж байгаа өвчтөнүүд , (2) хоол эмчилгээнд глюкозын хяналт сул өвчтөнүүд [38].

Ургийн өсөлтийг хянах – Бодисын солилцооны хяналт, инсулин эсвэл гипергликемийн эмийн хэрэгцээ зэргээс үл хамааран жирэмсний гурав дахь гурван сараас эхлэн сард нэг удаа, ЖЧШ-тэй 36-39 долоо хоногтой бүх өвчтөнд ургийн жинг тооцоолохын тулд хэт авиа шинжилгээг хийхийг зөвлөнө. Макросоми нь төрөх замын төрөх талаар шийдвэр гаргахад нөлөөлөх хүчин зүйлүүдийн нэг юм. (Доорх "Төрөх зам" сэдвийг үзнэ үү.)

Ажиглалтын арга, байгаа мэдээлэл өгөгдлийн хязгаарлагдмал байдлаас хамааран дараах өргөн хүрээний эмнэлзүйн удирдамж бий болсон байна [39,46,47]. Жишээлбэл:

- Зарим эмч нар ураг хэт томрохоос өмнө төрөлтийг өдөөх эх, ургийн талын байдлыг тодорхойлохын тулд 36-39 долоо хоногтой үнэлгээ, шинжилгээ хийдэг. ("Мөрний дисточи: эрсдэлт хүчин зүйлс ба эрсдэлтэй жирэмслэлтийн төлөвлөлт"-ийн "Чихрийн шижинтэй өвчтөнүүд" хэсгийг үзнэ үү.)
- Зарим эмч нар ургийн өсөлтийн хурдыг тодорхойлохын тулд нэг буюу хэд хэдэн хэт авиа шинжилгээг эрт хийж эхэлдэг (ЖЧШ оношлогдохоос өмнө ба 36 долоо хоног хүртэл), учир нь ургийн хэт өсөлт нь гликемийн хяналт оновчтой бус байгаагийн шинж тэмдэг бөгөөд макросоми үүсэх эрсдэлийг бууруулахын тулд гликемийн хяналтыг чангатгах шаардлагатай болно. Гэсэн хэдий ч эрт үеийн ургийн өсөлт хурдан байх нь төрөх үед жирэмсний хугацаанаас ураг том байхыг шууд үнэн зөв таамаглаж чадахгүй [47] ба ЖЧШ-гийн хатуу чанга ба дунд зэрэг хяналтыг харьцуулсан санамсаргүй хяналтат туршилт судалгаагаар нярайн ноцтой өвчлөлийг бууруулсан ч жирэмсний хугацаанаас ураг хэт том байх эрсдэлийн ялгааг бүлгүүдийн хоорондын харуулж чадаагүй [39].
- Зарим эмч нар А1 ЖЧШ-тэй эугликемитэй өвчтөнүүдэд ургийн өсөлтийг хэт авиа шинжилгээгээр хянадаггүй (зөвхөн хоол тэжээл эмчилгээ зөвлөнө) ба энэ нь хуурамч эерэг үр дүн үүсгэж ятрогенийн шалтгаантай хүндрэлд хүргэдэг гэсэн болгоомжлолоос үүдэлтэй юм. Жишээлбэл, нэг судалгаагаар жирэмсний 3-р гурван сард хэт авиа шинжилгээ хийлгэсэн өвчтөнүүдийн дунд жингээ хянаж байсан ч кесар мэс заслаар төрөх нь нэмэгдэж байгааг мэдээлсэн байна [48].

Ургийн өсөлтийг үнэлэх ямар ч арга хамгийн сайн биш тул ургийн жинг тооцоолоход хэцүү хэвээр байна. Одоогийн бүх аргууд, ялангуяа жирэмсний хугацаанаас ураг хэт том байхыг тодорхойлох аргуудын мэдрэг болон өвөрмөц байдал сул байна [49-51]. Инсулины эмчилгээ хийлгэсэн чихрийн шижинтэй жирэмсэн ээжүүдийг хамруулсан тойм судалгаагаар төрөх үеийн нярайн жин ≥ 4500 грамм байх магадлал 50%-иас доошгүй байлгахын тулд хэт авиа

шинжилгээгээр тооцоолсон ургийн жин ≥ 4800 грамм байх ёстойг тогтоожээ [52]. Чихрийн шижингүй жирэмсэн ээжүүдийг хамруулсан ижил төрлийн судалгаанууд ижил төстэй үр дүнг мэдээлсэн байдаг [53]. Судлаачид ургийн жинг тооцоолох илүү мэдрэг аргыг олохыг оролдсон боловч эдгээр туршилтын аргууд нь одоо байгаа хоёр хэмжээст хэт авианы технологийг сайжруулж чадна гэсэн нотолгоо бага байна [54-57]. Жирэмсний хугацаанаас ураг хэт том байх, макросоми оношны талаар тусад нь нарийвчлан авч үзнэ. ("Ургийн макросоми", "Оношилгоо" ба "Ургийн макросоми", "Чихрийн шижинтэй өвчтөнүүд" гэсэн хэсгийг үзнэ үү.)

Төрөхийн өмнөх үеийн хүндрэлийн эмчилгээ — Дээр дурдсанчлан нь ЖЧШ-тэй өвчтөнүүдэд дараах жирэмсний үеийн хүндрэлүүд илүү их тохиолддог. (Дээрх 'ЖЧШ-ийн үр дагавар' хэсгийг үзнэ үү.)

Презклампси ба жирэмсний даралт ихсэлт – Презклампси ба жирэмсний даралт ихсэлтийн эмчилгээ нь ЖЧШ-гүй үетэй адил байна. Хүнд хэлбэрийн гипертензийн эмчилгээнд Лабеталол хэрэглэж болно. ЖЧШ-тэй өвчтөнд гипогликеми шинж тэмдэггүй байх магадлал бага байдаг. ("Презклампси: Төрөхийн өмнөх эмчилгээ ба төрөх хугацаа", "Жирэмсний даралт ихсэлт", "Чихрийн шижинтэй насанд хүрэгчдийн гипогликеми" -бүлгийг үзнэ үү.)

Дутуу төрөлт – Дутуу төрөлтийг ЖЧШ-гүй өвчтөнүүдтэй нэгэн адил менежментээр зохицуулагдана. Индометацин ба нифедипин нь токолиз (жирэмслэлтийг уртасгах эх барихын процедур)-ийн эхний сонголтын эмүүд бөгөөд сонголт нь жирэмсний хугацаанаас хамаарна. Хэрэв эдгээр эмүүд эсрэг заалттай бол тербуталин хэрэглэж болох боловч бета агонистууд глюкозын хэмжээг ихэсгэдэг тул эхийн глюкозын түвшинг сайтар хянаж байх шаардлагатай. Өлөн үеийн глюкозын хэмжээ >100 мг/дл (5,5 ммоль/л) эсвэл хоолны дараах глюкоз >140 мг/мл (7,8 ммоль/л) байвал арьсан доорх инсулинаар эмчилнэ. ("Цочмог дутуу төрөлтийг дарангуйлах" хэсгийг үзнэ үү.) Төрөхийн өмнөх кортикостероидыг нэгэн зэрэг хэрэглэх нь глюкозын түвшинг нэмэгдүүлнэ. (Доорх 'Жирэмсний кортикостероидын хэрэглээтэй холбоотой гипергликеми' хэсгийг үзнэ үү.)

Төрөхийн өмнөх кортикостероидын хэрэглээтэй холбоотой гипергликеми – Хэрэв жирэмсний үед кортикостероидуудыг (ACS) хэрэглэх заалттай бол эхний стероидын тунгаас хойш ойролцоогоор 12 цагийн дараа гипергликеми үүсэж дунджаар тав хоног үргэлжилдэг байна [58,59]. Бетаметазоныг эхний тунг хэрэглэснээс хойш 12 цагийн дараагаас эхлэн захын цусан дахь глюкозын хэмжээг тогтмол (жишээ нь өдөрт дор хаяж 4 удаа, гэхдээ глюкозын түвшин, хянахад хүндрэлтэй эсэхээс хамаарч илүү олон хийж болно) хянах ба хоёр дахь тунг хэрэглэснээс хойш 24 цагийн турш глюкозын хяналт үргэлжилнэ. Дараа нь

глюкозын түвшинг зохих ёсоор хянаж чадвал хяналтын давтамжийг өдөрт 4 удаа болгон бууруулна. Хэрэв өлөн үеийн глюкоз 100 мг/дл (5,5 ммоль/л)-ээс ихэссэн, эсвэл хоол идсэний дараах түвшин 140 мг/мл (7,8 ммоль/л) -ээс дээш байвал арьсан доорх инсулин хийж эмчилнэ. Хэрэв арьсан доорх инсулины тун нэмэгдэж байгаа хэдий ч глюкоз нэмэгдсээр байх, эсвэл анхны хэмжилтийн утга 180 мг/дл (10.0 ммоль/л) -ээс дээш байвал бид эмнэлгийн нөхцөлд инсулиныг тасралтгүй дуслар тарих байдлаар эмчилгээг эхлүүлнэ. ("Жирэмсэн үеийн (өмнөх) чихрийн шижин: Эх барихын асуудал ба менежмент", "Дутуу төрөх эрсдэлтэй өвчтөнд жирэмсний үеийн глюкокортикоидууд" хэсгийг үзнэ үү.)

Чихрийн шижинтэй эхэд жирэмсний ≥ 34 долоо хоногтой үед ACS хэрэглэхийг зөвлөхгүй. Хожуу үеийн дутуу төрөлтийн үед стероид хэрэглэх (ALPS) туршилт судалгаагаар хожуу жирэмслэлтийн үед бага зэргийн ашиг тустай байсан ч гликемийн хяналтад нөлөөлөх эсэхээс болж чихрийн шижинтэй бол судалгаанаас хассан байна. ("Нярайн амьсгалын замын өвчлөл, дутуу төрөлтөөс үүдэлтэй нас баралтыг бууруулах зорилгоор жирэмсний үеийн кортикостероид эмчилгээ"-хэсгийг үзнэ үү.)

Макросоми ба мөрний дистоци үүсэх эрсдэлийг таамаглах/урьдчилан сэргийлэх – Макросоми (ЖЧШ-гийн үед ≥ 4500 гр байхаар тодорхойлогдоно) нь хэт авиа шинжилгээгээр оношлогддог бөгөөд ихэвчлэн полигидрамниоз дагалдаж илэрнэ. Гол анхаарал татах асуудал бол төрөх үед мөрний дистоци үүсэх эрсдэл юм. Мөрний эмгэг, ялангуяа эх, нярайн болзошгүй өвчлөлөөс урьдчилан сэргийлэхийн тулд ЖЧШ-тэй, ургийн тооцоолсон жин ≥ 4500 гр байгаа тохиолдолд төлөвлөгөөт кесар мэс заслаар төрөлтийг удирдахыг санал болгодог. (Доорх "Төрөх зам" сэдвийг үзнэ үү.) Ургийн жин 4500 гр-аас бага тохиолдолд төрөлтийг удирдах шийдвэр гаргах, хүлээгдэж буй менежментийг тусад нь авч үзнэ. ("Мөрний дистоци: эрсдэлт хүчин зүйлс ба эрсдэлтэй жирэмслэлтийн төлөвлөлт"-ийн "Чихрийн шижинтэй өвчтөнүүд" хэсгийг үзнэ үү.)

Төрөх хугацаа – ЖЧШ-тэй өвчтөнүүдийг эмчлэх гол асуудлын нэг бол төрөлтийг сэдээх эсэх, хэрэв тийм бол хэзээ вэ гэдэг асуудал юм. Төрөлтийг сэдээхийн ашиг тус нь хожуу амьгүй төрөлтөөс зайлсхийх, ургийн тасралтгүй өсөлтөөс шалтгаалан төрөлттэй холбоотой хүндрэлээс зайлсхийх, тухайлбал, мөрний дистоци эсвэл төрлөгийн явцад кесар мэс засал руу шилжих зэрэг эрсдэлээс сэргийлэх боломжтой. Харин сул талууд нь сэдээлтийн эрсдэлүүд (жишээ нь, төрөлт удаан үргэлжлэх, ажилбар хийх хандлага нэмэгдэх) үүсэх ба хэрэв 39 долоо хоногоос өмнө төрөлтийг сэдээвэл нярайн өвчлөл ихэсдэг [43]. Сэдээх нь ЖЧШ-тэй өвчтөнүүдэд хийгдэх менежментээс илүүтэйгээр кесар мэс заслаар төрөлтийг удирдах байдлыг ихэсгэдэггүй нь сүүлийн үеийн судалгаануудаар батлагдаж байна [60-62].

ЖЧШ-тэй үед төрөх хугацааг хамгийн оновчтойгоор сайн боловсруулсан туршилт, судалгаа, зөвлөмж одоогоор байхгүй байна. Боломжтой судалгаанууд [60,63-68] нь нотлох баримтад суурилсан хүчтэй зөвлөмж гаргахад хангалтгүй; иймээс дэлхий даяар практик харилцан адилгүй байна [69,70]. Бидний санал болгож буй арга барил нь олон байгууллагуудад бий болсон практикийн загвартай төстэй бөгөөд үндсэндээ өвчтөн А1 эсвэл А2 ЖЧШ, глюкозын хяналт хангалттай эсэх дээр суурилна.

Глюкозын сайн хяналттай А1 ЖЧШ – Зөвхөн хоол тэжээлийн эмчилгээ, дасгал хөдөлгөөн (А1 ЖЧШ) хэрэглэснээр эугликеми байгаа тохиолдолд $\geq 39+0$ долоо хоногтой сэдээлт хийх эсвэл $41+0$ долоо хоног хүртэл хүлээх тал дээр хэлэлцэж байна. А ангиллын чихрийн шижинтэй 196 өвчтөнийг хамруулсан сонгодог хяналтын бүлэггүй тохиолдлын судалгаанд сэдээлтийн арга хэрэглэхгүй байх нь харьцангуй илүү үр дүнтэй байгааг мэдээлсэн байна [40]. Эмнэлзүйн практик нь эмнэлэг тус бүрд харилцан адилгүй байдаг ч эдгээр өвчтөнүүдийг жирэмсний $39+0$ долоо хоногоос өмнө [71] эсвэл $41+0$ долоо хоногоос хойш төрүүлж болохгүй гэдэгтэй ерөнхийдөө санал нэг байна. $39+0$ -аас $41+0$ долоо хоногийн хооронд сэдээлт хийх талаар маргаантай хэвээр байна.

Шийдвэрийн шинжилгээг ашиглан хийсэн судалгаагаар ураг ба нярайн эндэгдлийг жирэмсний 38 долоо хоногтойд төрөхөд бууруулж болохыг тогтоосон ч энэ математик загвар дангаараа бидний эмнэлзүйн практикийг өөрчлөхөд хангалтгүй [72]. Америкийн Эх барих эмэгтэйчүүдийн эмч нарын коллеж (ACOG) нь жирэмсний $39+0$ долоо хоногоос өмнө төрөлтийг төлөвлөх ёсгүй бөгөөд жирэмсний хяналтад $40+6$ долоо хоног хүртэлх хугацааг ерөнхийдөө тохиромжтой гэж үзжээ

Глюкозын хяналт муу А1 ЖЧШ ба А2 ЖЧШ – Глюкозын түвшинг инсулин эсвэл гипергликемийн эмээр (А2 ЖЧШ) хянаж буй, эсвэл глюкозын хяналт муу А1 ЖЧШ-тэй тохиолдолд бид жирэмсний $39+0$ долоо хоногт сэдээлт хийн төрөлтийг удирдахыг санал болгож байна. Уг зөвлөмжийг ЖЧШ-тэй өвчтөнүүдийн ретроспектив когортын судалгааны үр дүн болох $39+0$ долоо хоногт нялхсын эндэгдлийн түвшин ($10,000$ -аас $8,7$) статистикийн хувьд амьгүй төрөлт болон нярайн эндэгдлийн ($10,000$ -аас $15,2$) эрсдэлээс бага байсан мэдээлэлд үндэслэсэн [43]. Үүнээс гадна сэдээлт нь хожуу төрөлттэй харьцуулахад мөрний дисточи үүсэх эрсдэлийг бууруулдаг ба учир нь умайд ургийн үргэлжилсэн хэт өсөлт байхгүй тохиолдолд жин бага байх ёстой [63,64]. Жирэмсний $37+0$ -ээс $38+6$ долоо хоногийн хугацаанд нярайн өвчлөлийн түвшин нэмэгдсэн ч амьгүй төрөх эрсдэл бага байдаг [73] тул глюкозын сайн хяналттай, хүндрэлгүй А2 ЖЧШ-гийн үед төрөлтийг хугацаанаас эрт үед ($37+0$ -ээс $38+6$ долоо хоног) сэдээхгүй. Гэсэн хэдий ч, хэрэв дагалдах эмгэг (жишээлбэл, цусны даралт ихсэх) байгаа эсвэл эмийн эмчилгээнд гликемийн хяналт муу байгаа

тохиолдолд жирэмсний 39+0 долоо хоногоос өмнө эмнэлзүйн заалтын дагуу төрөлтийг сэдээн удирдах ёстой [63,64].

Мөн ургийн жинг анхаарч үзэх хэрэгтэй. Жирэмсний хугацаанд ургийн жин тохирсон (AGA) байхтай харьцуулахад жирэмсний хугацаанд ургийн жин хэт том (LGA) байгаа бүлэгт амьгүй төрөлтийн эрсдэл нэмэгддэг. Жишээлбэл, ЖЧШ-гийн хүндрэлтэй жирэмслэлтийн судалгаагаар LGA болон AGA ураг 38 долоо хоногт амьгүй төрөх үнэмлэхүй эрсдэл 10,000 жирэмслэлт тутамд 21.5 ба 4 тус тус байсан ба мөн 39 долоо хоногт 10,000 жирэмслэлт тутамд 20.7 ба 5.7 байна [45]. Эдгээр мэдээллийн хязгаарлагдмал тал нь гликемийн хяналт, эм хэрэглэх шаардлагатай өвчтөнүүдийн талаарх мэдээлэл болон хоол, дасгал хөдөлгөөн эмчилгээ авсан өвчтөнүүдийн талаар мэдээлэл байхгүй байв.

Америкийн Эх барих эмэгтэйчүүдийн эмч нарын коллеж (ACOG)-оос эмээр сайн хянагдаж байгаа А2 ЖЧШ-тэй өвчтөнүүдийг жирэмсний 39+0-ээс 39+6 долоо хоногтойд төрөхийг санал болгож байна [73]. Гэсэн хэдий ч гликемийн хяналт муу байгаа тохиолдолд фармакологийн эмчилгээний талаарх зааварчилгаа нь нарийвчлал багатай байна. Энэ тохиолдолд жирэмсний 37+0-аас 38+6 долоо хоногтойд төрүүлэх нь зүйтэй гэж зөвлөж байна. Харин цусан дахь глюкозыг сайн хяналтыг эмнэлэгт хэвтүүлэн хийсэн ч үр дүнгүй байгаа тохиолдолд 37+0 долоо хоногоос өмнө төрөлтийг эхлүүлэхийг зөвлөж байна. [38].

Төрөх зам – Ургийн жин нь шийдвэр гаргахад чухал ач холбогдолтой байна.

- **Ургийн тооцоолсон жин ≥ 4500 гр байгаа тохиолдолд** – ЖЧШ-тэй, 39+0 долоо хоногтой, ургийн тооцоолсон жин ≥ 4500 гр байгаа тохиолдолд төрөх үеийн гэмтлээс зайлсхийхийн тулд төлөвлөгөөт кесар мэс заслаар төрөлтийг удирдана. Мөрний дистоциа-с үүдэлтэй төрөх үеийн гэмтлийн эрсдэлийг бууруулахын тулд төлөвлөгөөт кесар мэс засал хийх ургийн жингийн заалт маргаантай байдаг. ЖЧШ-тэй, ургийн тооцоолсон жин ≥ 4500 гр байгаа жирэмсэн ээжүүдийг хамруулсан судалгаанд мөрний сүлжээний гэмтлээс сэргийлэх зорилгоор 443 тохиолдолд кесар мэс засал хийсэн байна [74]. Энэ нь кесар хагалгаагаар төрөх эрсдэл нэмэгдэж байгааг зөвтгөж байгаа эсэх нь тодорхойгүй байна. Америкийн Эх барих эмэгтэйчүүдийн эмч нарын коллежоос гаргасан ЖЧШ-ийн практик мэдээллийн эмхэтгэлд ЖЧШ-тэй, ургийн тооцоолсон жин ≥ 4500 гр [38] байгаа өвчтөнүүдтэй төлөвлөгөөт кесар мэс заслын үр ашиг, эрсдэлийн талаар хэлэлцэхийг зөвлөж байна. Хэрэв ЖЧШ-тэй, ургийн тооцоолсон жин ≥ 4500 гр байгаа үед төрөлтийг төрөх замаар удирдахаар шийдсэн бол төрөлтийн явцыг анхааралтай хянах, төрлөгийн хоёр дахь үе хэвийн явагдсан тохиолдолд л багажийн тусламжтайгаар төрөх замаар төрүүлнэ. Учир нь хямсаа эсвэл вакуум тусламжтайгаар төрөх нь мөрний дистоци болон мөрний сүлжээний

гэмтэл үүсгэх эрсдэл өндөртэй байдаг ба хямсаатай харьцуулахад вакум хэрэглэвэл бүр ч өндөр эрсдэлтэй байдаг [75,76]. ("Мөрний дисточи: Өндөр эрсдэлтэй жирэмслэлтийн эрсдэлт хүчин зүйлс ба төрөлтийг төлөвлөх", "Өндөр эрсдэлтэй жирэмслэлтийн төрөлтийг төлөвлөх" хэсгийг үзнэ үү.)

- **Ургийн тооцоолсон жин <4500 гр байгаа тохиолдолд** — Кесар мэс заслын аргаар төрөлтийг удирдахыг эх барихын стандарт заалтын дагуу шийдвэрлэнэ.
- **Төрөх ба төрсний дараах үеийн гликемийн хяналт** – Төрөх үйл явц эхэлснээр амаар орох илчлэгийн хэмжээ багасаж, ялангуяа умайн агшилт нь нэмэлт эрчим хүч шаарддаг учраас төрөх үед инсулины хэрэгцээ ихэвчлэн буурдаг. Төрлөгийн үеийн глюкозын түвшин нь 70-125 мг/дл (3.9-6.9 ммоль/л) байх ёстой. Нярайн гипогликеми үүсэх эрсдэлийг бууруулахын тулд гипергликемийн эсрэг эмчилгээ хийдэг. Нярайд гипогликеми удаан үргэлжлэх нь ураг байх үеэс эхийн гипергликемид өртөж байсантай холбоотой бөгөөд энэ нь ургийн нойр булчирхайн гиперплази үүсгэснээр нярайн гипогликеми удаан үргэлжлэх эрсдэлтэй. Харин түр зуурын гипогликеми нь төрөх үеийн эхийн гипергликеми үүссэнээр ургийн инсулины огцом өсөлт үүсдэгтэй холбоотой [77-81].
- **A1 ЖЧШ** – Жирэмслэлтийн үед инсулин эсвэл гипергликемийн эм хэрэглэхгүйгээр эугликеми байгаа ЖЧШ-тэй өвчтөнүүд ихэвчлэн төрөх болон төрсний дараах үед гипергликеми үүсгэдэггүй тул цусан дахь глюкозын түвшинг шалгах шаардлагагүй байдаг. Гэвч зарим эмч, эмнэлэгт амбулаториос гадна чихрийн шижингийн өөрийн хяналт нь үнэн зөв эсэхэд санаа зовдог тул төрлөгийн үед цусан дахь глюкозын түвшинг шалгадаг.
- **A2 ЖЧШ** – Төрөхөөс өмнө инсулин эсвэл гипергликемийн эсрэг эм хэрэглэж байсан ЖЧШ-тэй өвчтөнүүдэд төрөх болон төрсний дараах үед глюкозын түвшинг зорилтот түвшинд байлгахын тулд инсулин эмчилгээ шаардлагатай байж болно. Төрөх үеийн эхийн гипергликеми нь нярайн таагүй үр дагаварт хүргэдэггүй ч эхийн глюкозын түвшинг үе үе үнэлж, гипергликемийн эмчилгээг болгоомжтой хийнэ [82]. Өөрөө аяндаа төрөх, сэдээлтээр төрөх, төлөвлөгөөт кесар мэс заслаар төрөх үеийн глюкозын хяналт, шингэн сэлбэлт, инсулин, гипергликемийн эмийн менежментийн талаар тусад нь авч үзнэ. ("Жирэмсний өмнөх (өмнө нь оношлогдсон) болон жирэмсний үеийн чихрийн шижин: Төрөх үеийн болон төрсний дараах үеийн глюкозын менежмент" хэсгийг үзнэ үү.)

ТӨРСНИЙ ДАРААХ ТУСЛАМЖ

ЖЧШ-тэй өвчтөнүүд төрсний дараа хэвийн хооллолтдоо эргэн орох боломжтой байх ёстой.

Хөхөөр хооллох – Хөхөөр хооллох нь эх, хүүхдэд аль алинд нь ашигтай байдаг тул хөхөөр хооллохыг дэмжих хэрэгтэй. ("Хүүхдийг эхийн сүүгээр хооллох нь эхийн болон эдийн засгийн үр өгөөж", "Хүүхдийг эхийн сүүгээр хооллохын ашиг тус" хэсгийг үзнэ үү.)

Хөхөөр хооллох нь эхийн глюкозын метболизмыг сайжруулдаг. Төрсний дараа глюкозын тэсвэржилтийн шинжилгээ хийж үзэхэд глюкозын түвшин харьцангуй буурсан байдаг ба ялангуяа шинжилгээ өгч байх үеэр хөхөөр хооллож байсан бол илүү буурсан байна [83-85]. Онолын хувьд энэ нь хуурамч үр дүн гэж үзэж болзошгүй юм.

Хэд хэдэн проспектив судалгаагаар ЖЧШ оношлогдсон бүлэгт хөхөөр хооллох нь хөхөөр хооллоогүй бүлэгтэй харьцуулахад чихрийн шижин хэв шинж 2-ын урт хугацааны тохиолдлыг илүү бууруулж байсан байна [87-90]. Эрчимтэй, урт хугацаагаар хөхүүлэх нь эрсдэлтэй урвуу хамааралтай байсан ба жин хасахаас үл хамааран чихрийн шижин хэв шинж 2 өвчний эрсдэлт хүчин зүйлс (нийгмийн хүн ам зүйн шинж чанар, пренатал бодисын солилцооны байдал түүний явц, перинаталь үр дүн, амьдралын хэв маяг) буюу төөрөгдүүлэгч хүчин зүйлсээр засварласны дараа энэхүү үр дүн батлагдаж байв.

Жирэмслэлтээс хамгаалах арга – Эсрэг заалт байхгүй тохиолдолд жирэмслэлтээс хамгаалах аливаа аргыг хэрэглэхийг зөвшөөрдөг боловч удаан хугацааны үр дүнтэй жирэмслэлтээс хамгаалах хэрэгслийн (жишээ нь, умайн спирал [IUD], жирэмслэлтээс хамгаалах суулгац) давуу тал нь төлөвлөөгүй жирэмслэлтийн эрсдэл багатай, амар хялбар байдаг [91]. Системийн дааврын түвшин багатай жирэмслэлтээс хамгаалах бэлдмэлийг сонгох нь онолын хувьд бодисын солилцооны үзүүлэлтүүдийн өөрчлөлтийг бууруулна. Хэрэв өвчтөн дааврын асуудалд санаа зовж байгаа бол зэс ялгаруулдаг умайн спирал [IUD] нь сайн хувилбар юм. Гэсэн хэдий ч жирэмслэлтээс хамгаалах дааврын бэлдмэл (эстроген-прогестин эсвэл зөвхөн прогестин) нь чихрийн шижин хэв шинж 1 ба 2 үүсэх эрсдэлийг нэмэгдүүлдэг гэсэн баттай нотолгоо байхгүй байна [92]. ("Жирэмслэхээс хамгаалах арга: Зөвлөгөө ба сонголт" хэсгийг үзнэ үү.)

Үргэлжилсэн чихрийн шижинг илрүүлэх – Төрсний дараа ихсийн дааврын гипергликемийн нөлөө хурдан арилдаг. Тиймээс ихэнх өвчтөнүүд төрснөөс хойш удалгүй жирэмсний өмнөх үеийн гликемийн байдалдаа ордог бөгөөд ихэвчлэн дөнгөж төрсний дараа болон төрснөөс хойш 7 хоногтоо хэвийн байдалдаа ордог. Төрөхийн өмнө гипергликемийн эм хэрэглэж байсан ихэнх өвчтөнүүд төрсний дараа хэрэглэх шаардлагагүй байдаг.

- **Төрсний дараах глюкозын түвшинг хянах** – ЖЧШ-тэй зарим өвчтөнд урьд нь оношлогдоогүй чихрийн шижин хэв шинж 2 өвчтэй байж болох тул төрсний дараа гипергликеми үргэлжилж байгаа эсэхийг үгүйсгэхийн тулд глюкозын концентрацийг шалгах шаардлагатай. А1 ЖЧШ-тэй өвчтөнд зөвхөн нэг удаагийн глюкозыг шалгаж, хэвийн бол цусан дахь глюкозын хэмжээг дахин шалгахгүй байж болно. А2 ЖЧШ -тэй өвчтөнд 24 цагийн турш глюкозын түвшинг шалгаж, өлөн үеийн болон хоол идсэний дараа цусан дахь глюкозын аль алиныг нь шалгах бөгөөд хэрэв хэвийн бол дахин хянах шаардлагагүй. Хэрэв ямар нэгэн утга хэвийн бус байвал байнгын эмчилгээ шаардлагатай эсэхийг тодорхойлохын тулд эмнэлэгт хэвтэх, магадгүй гэртээ байх үеийн глюкозын түвшинг үргэлжлүүлэн хянахыг зөвлөнө. Хэрэв өлөн үеийн глюкозын концентраци нь илэрхий чихрийн шижин өвчнийг илтгэж байвал (өлөн үеийн глюкоз ≥ 126 мг/дл [7 ммоль/л] эсвэл хоол идсэний дараах глюкоз ≥ 200 мг/дл [11.1 ммоль/л]) байвал гипергликемийг эмчлэх шаардлагатай ба эмчилгээний төрлийг (хоолны дэглэм, дасгал хөдөлгөөн, жингээ хасах, эм уух) тохиолдол тус бүрт тохируулан шийдэх бөгөөд дотоод шүүрэл булчирхайн эмч эсвэл анхан шатны тусламж үйлчилгээ үзүүлэгчээс зөвлөгөө авах шаардлагатай. Шаардлагатай тохиолдолд төрсний дараах глюкозын хяналт, эмчилгээг тусдаа бүлгээс үзнэ үү. ("Жирэмсний өмнөх (өмнөх) болон жирэмсний үеийн чихрийн шижин: Төрөх үеийн болон төрсний дараах үеийн глюкозын менежмент", "Жирэмсний чихрийн шижин" хэсгийг үзнэ үү.)
- Төрсний дараах 4-12 долоо хоногт ГАС хийх – Глюкозын түвшин хэвийн/хэвийн байдалтай ойролцоо байгаа тохиолдолд чихрийн шижин, предиабет байгаа эсэхийг үнэлэх зорилгоор төрснөөс хойш 4-12 долоо хоногийн дараа 75 гр глюкозоор Глюкозын Ачаалалтай Сорил (ГАС) хийнэ (хүснэгт 1). ("Жирэмсний үеийн чихрийн шижин: Глюкозын менежмент ба өвчний явц", "Давтан хяналт" хэсгийг үзнэ үү.)
- Чихрийн шижин гэж оношлогдсон хүмүүсийг (хүснэгт 1) эмнэлгийн тусламжийн дагуу эмчилнэ. ("Насанд хүрэгчдийн чихрийн шижин хэв шинж 2 өвчний гипергликемийн анхан шатны эмчилгээ" -ийг үзнэ үү.)
- ГАС хэвийн эсвэл предиабет байвал (хүснэгт 2) цаашид чихрийн шижин хэв шинж 2, зүрх судасны өвчнөөр өвчлөх эрсдэлийн талаар тайлбарлан зөвлөгөө өгч, эрсдэлийг бууруулахын тулд амьдралын хэв маягийг өөрчлөх (жишээлбэл, эрүүл хооллолт, турах, дасгал хийх), анхан шатны тусламж үйлчилгээний хяналтад ойрхон хяналтад үзүүлэх, зохих давтамжтайгаар давтан шинжилгээнд хамруулахын ач холбогдлын талаар мэдээлэл өгнө. Эдгээр асуудлыг дараах бүлэгт тусад нь нарийвчлан авч үзнэ. ("Жирэмсний үеийн чихрийн шижин: Глюкозын менежмент ба өвчний явц", "Хяналт" болон "Чихрийн шижин хэв шинж 2 өвчнийг эрт илрүүлэх шинжилгээ" болон "Насанд

